

## Зардлын норматив шинэчлэн батлах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.5, Төсвийн тухай хуулийн 11.1.3-т заасныг үндэслэн ХНХЯ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалаар баталсан Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж нормативыг мөрдөж байна. Уг тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж зах зээлийн үнийн судалгаа хийж шинэчлэх чиглэлийг Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 448 дугаар тогтоол Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний 1.4 дэх хэсэгт Хүүхдийн асрамжийн төвийн үйл ажиллагааны зардлын нормативыг бодит өртгөөр нь тооцож шинэчлэн баталж мөрдүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ, арга хэмжээний төсвийг салбар хоорондын уялдаа холбоог хангасан байхаар тооцож зарцуулах талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж, хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад үүрэг болгосон. Энэ хүрээнд төрөлжсөн асрамжийн төвүүдийн үйлчилгээний нөхцөл байдал, зах зээлийн судалгаа хийж, халамж асрамжийн төвүүдэд хэлэлцүүлж дараах өөрчлөлтийг хийлээ. Үүнд:

ЗГ-ын 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 52/А/20 дугаар тушаалаар өөрчлөлт оруулан 18 хүртэлх насны хүүхдийн хоногт хэрэглэх хоолны хэмжээ, илчлэгийг нэмэгдүүлсэн.

1. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив дундаж зардлыг батлахдаа хүүхдийн насны ангиллыг 1-5 нас, 6-12 нас, 13-18 нас гэсэн 3 ангилал байсныг өөрчилж БШУЯ, ЭМЯ, СЯ-ны Сайдын хамтарсан А/166, А/559, 222 тушаалын хоёр, гуравдугаар хавсралтад тусгасан ангиллыг нэмж, 1-3 нас, 4-6 нас, 7-10 нас, 11-14 нас, 15-18 нас хэмээн 5 ангиллыг баримталж тус тусад нь норматив зардлын тооцоог гаргасан.
2. ХНХЯ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт болох төрөлжсөн асрамжийн газрын үйлчилгээнд хамрагдаж байгаа 0-4 настай гурав түүнээс дээш ихэр хүүхдийн хувцас, ариун цэврийн хэрэглэлийн зардлын дундаж норматив, эдэлгээний хугацаа гэсэн тусдаа хавсралтыг хасаж, нэг хүүхдэд ноогдох норматив зардлаар тооцож байхаар өөрчилсөн. Энэ нь тус хавсралтын 2-18 настай хүүхдийн хувцас, ариун цэврийн хэрэглэлийн зардлын дундаж норматив, эдэлгээний хугацаа гэсэн хавсралттай логикийн зөрчилтэй, түүнчлэн үнийн зөрүүтэй байна. Хүүхдийг ихэр хэмээн онцлохгүйгээр нийтлэг нэг хүүхдийн хувьсах зардлаар тооцох боломжтой гэж үзсэн.
3. ХНХЯ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтад хүүхдийн хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив нь 1-5 настай хүүхдэд 4098 төгрөг, 6-12 настай хүүхдэд 5734 төгрөг, 13-18 настай хүүхдэд 7464 төгрөг байхаар баталсан байна. Энэ нь 2023 оны бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт,

зах зээлийн бодит үнэтэй нийцэхгүй бага байна. Үүнийг 0-3 настай хүүхдэд 6742-11209 төгрөг, өмнөх зардлаас 2644-7111 төгрөгийн зөрүү; 4-6 настай хүүхдийн хоолны зардал 8109 төгрөг, өмнөх зардлаас 2375 төгрөгөөр өссөн, 7-10 настай хүүхдийн хоолны зардал 9802 төгрөг буюу өмнөх зардлаас 4068 төгрөгөөр, 11-14 настай хүүхдийн хоолны зардал 12452 төгрөг буюу өмнөх зардлаас 4988 төгрөг, 15-18 настай хүүхдийн хоолны зардал 13506 төгрөг буюу өмнөх зардлаас 6042 төгрөгөөс нэмэгдэж олгогдох тооцоолол гарсан. Энэ нь өмнөх зардлыг бараа бүтээгдэхүүний үнийн бодит үнийн өсөлттэй уялдуулан 16-18 хувь нэмэгдүүлж тооцсон (Тайлангийн хүснэгт 9. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хоногт хэрэглэх хоолны зардлын дундаж норматив харьцуулалтаас харна уу).

**Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хоногт хэрэглэх хоолны зардлын дундаж норматив харьцуулалт**

№		0-12 сар	1-3 нас	4-6 нас	7-10 нас	11-14 нас	15-18 нас
1	Хүүхдийн хоногт хэрэглэх хүнсний зардлын дундаж норматив (2021 оны байдлаар)	1-5 нас		6-12 нас		13-18 нас	
		4098 төг		5734 төг		7464 төг	
2	Хүүхдийн хоногт хэрэглэх хүнсний зардлын дундаж норматив (2023 оны санал)	6742-11209 төг	8109 төг	9802 төг	12452 төг	13506 төг	
<b>Зөрүү+</b>		<b>2644-7111 төг</b>	<b>2375 төг</b>	<b>4068 төг</b>	<b>4988 төг</b>	<b>6042 төг</b>	

4. ХНХЯ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтад хүүхдийн хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж нормативд хоолны нэр төрлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд, эрүүл мэндийн сайд, сангийн сайдын хамтарсан тушаал 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Дугаар А/166, А/559, 222 тоот тушаалтай нийцүүлэн тооцсон.

5. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хувцас ариун цэвэр, хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж нормативд дараах үнийн өөрчлөлтийг оруулах саналтай байна. Үүнд:

-ХНХЯ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтад төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэвэр, хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж норматив, эдэлгээний хугацааг тооцохдоо хүүхдийн насны ангиллыг 0-4 нас, 2-18 нас гэсэн

хоёр ангиллыг баримталсан нь хүүхдийн бие махбодын өсөлт, онцлог, хувцас бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй бодитоор уялдахгүй давхардсан хэмээн үзэж 0-5 нас буюу сургуулийн өмнөх нас, 6-18 нас буюу сургуулийн насны гэсэн 2 ангиллыг нэмж тусгасан, гутал, хувцас, дүрэмт хувцас, хичээлийн хэрэглэл, ариун цэврийн бараа бүтээгдэхүүний үнийг тооцсон.

-ХНХЯ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтад 0-4 настанд гутал болон гадуур хувцасны багц 286300 төг, дотуур хувцас 80200-85200 төгрөг, ариун цэврийн хэрэглэл 51600 төгрөг, зөөлөн эдлэлийн багц 97900 төгрөг буюу нийт 516000-521000 төгрөг байхаар, 2-18 настанд гутлын болон гадуур хувцасны багц 395550 төгрөг, дотуур хувцас 87200-92600 төгрөг, хичээлийн хэрэглэл 212000 төгрөг, ариун цэврийн хэрэглэл 134500 төгрөг, зөөлөн эдлэлийн багц 256700 төгрөг буюу нийт 1085950-1091350 төгрөг байхаар баталсан байна. Эдгээр хувьсах зардлыг 0-5 нас буюу сургуулийн өмнөх насны нэг хүүхдэд 1098100 төгрөг, сургуулийн насны 6-18 насны нэг хүүхдэд 1569150 төгрөг байхаар тооцсон. Энэ үнэ нь сурагчдын дүрэмт хувцасны үнийн ялгаатай байдлаас хамааран 300000-860500 төгрөгөөр нэмэгдэх төлөвтэй байна.

- ХНХЯ-ны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтад тусгагдсан зарим бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхгийг нэмэгдүүлсэн. Тухайлбал охидын ариун цэврийн хэрэглэл, хичээлийн хэрэглэл зэрэг болно.

**Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хувцас ариун цэвэр, хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж норматив харьцуулалт**

	<b>Хэрэглээний төрөл</b>	<b>2021 оны байдлаар</b>		<b>2023 оны санал</b>	
		<i>Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн (0-4 нас)</i>	<i>2-18 насны хүүхэд</i>	<i>0-5 насны хүүхэд (Сургуулийн өмнөх нас)</i>	<i>6-18 насны хүүхэд (Сургуулийн нас)</i>
1	Хүүхдийн гутлын багц	286300 төг	395550 төг	220000 төг	350000 төг
2	Гадуур хувцасны багц			395000 төг (+150000)	598000 төг
3	Дотуур хувцасны багц	80200-85200 төг	87200-92600 төг	173000 төг	190000 төг
4	Дүрэмт хувцасны багц	-	212000 төг	-	377000 төг
5	Хичээлийн хэрэглэлийн багц	-		-	176350 төг
6	Ариун цэврийн хэрэглэлийн багц	51600 төг	134500 төг	146100 төг	414300 төг

7	Зөөлөн эдлэлийн багц	97900 төг	256700 төг	164000 төг	324000 төг
<b>Нийт</b>		<b>516000-521000</b>	<b>1085950-1091350</b>	<b>1098100 (+300000)*</b>	<b>1569150 (+860500)**</b>
<b>Зөрүү+</b>				582100	

*Тайлбар: \* Хүүхдийн памперс, живх болон өлгий, даавууны багцийн үнэ нэмэгдэнэ.*

*\*\* Өвлийн куртик, хавар намрын куртик биеийн тамирын хослол, сурагчдын цүнх, гудас матраас, хөнжил орны бүтээлэг зэрэг 24 сараар хэрэглэдэг хэрэглээний үнэ нэмэгдэнэ.*

Мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын санал дээр үндэслэн, зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, хувцас, ариун цэврийн хэрэглэлийн тоо хэмжээ, нэр төрөлд өөрчлөлт оруулав.

Түүнчлэн “Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт” дахь эм, эмнэлгийн хэрэгсэл нь зөвхөн яаралтай тусламж үзүүлэх үед зарцуулж, бэлэн байдлыг хангах зориулалттай, харин ахмадуудын өдөр тутам хэрэглэдэг цусны даралт бууруулах, уналтын эсрэг эм зэрэг нэн шаардлагатай эм хангалтгүй тул байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу 10 гаруй төрлийн эмийг жагсаалтад нэмж тушаалын төсөлд тусгав.

Одоогийн мөрдөж байгаа тушаалаар насанд хүрэгсдийн хоногийн хоолны зардал хоногт 5205 төгрөг байгааг 7588 төгрөг, хувцас, зөөлөн эдлэлийн зардал насанд хүрэгсдийнх жилд дунжаар 387 000 төгрөг байгааг 564 950 төгрөг болгон тус тус нэмэгдүүлэн тушаалын төсөлд тусгав.

----oO----